



**НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/81

Улаанбаатар хот

Байгууллагын зохион байгуулалтын
бүтэц, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтэц, тэдгээрийн орон тооны хязгаарыг батлах тухай” Засгийн газрын 2019 оны 100 дугаар тогтоол, “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/241, А/1236 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

- 1.Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
- 2.Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалтыг батлах тухай Газрын даргын 2019 оны А/27 дугаар тушаалыг 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай
- 3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ж.Амармаа/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ГАЛЫМБЕК



Нийслэлийн Агаарын Бохирдолтой Тэмцэх Газрын
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн
2019 оны ./. дүгээр сарын ./.-ны өдрийн
1/81 дүгээр тушаалын хавсралт

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

д/д	Албан тушаалын нэр	Ангилал, зэрэглэл	Орон тоо
1	Дарга	T3-11	1
2	Орлогч дарга	T3-10	1
Захиргааны хэлтэс			
3	Хэлтсийн дарга	T3-9	1
4	Хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	T3-6	1
5	Хяналт, шинжилгээ үнэлгээ, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
6	Төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
7	Сургалт, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
8	Архив, бичиг хэргийн эрхлэгч	TY-5	1
Бодлогын хэрэгжилтийн хэлтэс			
9	Хэлтсийн дарга	T3-9	1
10	Гэр хорооллоос үүдэлтэй агаарын бохирдлын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	T3-6	1
11	Хэсэгчилсэн дулаан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
12	Түлшний бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
13	Авто тээврийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
14	Төлөвлөлт, гүйцэтгэл, тооцоо, судалгаа хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
15	Агаарын бохирдлын нөлөөлөл, тархалтын загварчлал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
16	Дотоод орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
17	Диспетчер	TY-4	15
Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтэс			
18	Хэлтсийн дарга	T3-9	1
19	Ахлах мэргэжилтэн / Хөдөлгөөнт эх үүсвэрийн хэмжилтийн чиг үүрэг хэрэгжүүлнэ/	T3-6	1

20	Агаар бохирдуулах суурин эх үүсвэрийн хэмжилт хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
21	Агаарын чанарын хяналт хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
22	Орчны хэмжилт хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
23	Оператор-техникч	TУ-5	3